

ТАНИЛЦУУЛГА

Хүнсний гол нэрийн барааны үнэ,
2018 оны 6-р сарын 20-ны байдлаар


2018 оны 6-р сарын 20-ны байдлаар гол нэрийн барааны үнийг өмнөх сартай харьцуулахад 2.4 хувь, өмнөх 7 хоногтой харьцуулахад 1.3 хувиар өссөн байна.

Махны дундаж үнэ: 2018 оны 6-р сарын 20-ны байдлаар хонины ястай махны үнэ өмнөх сараас өөрчлөлтгүй байсан бол үхрийн ястай махны үнэ 5.4 хувь, үхрийн цул махны үнэ 5.9 хувь, ямааны ястай махны үнэ 4.5 хувь, адууны ястай махны үнэ 8.6 хувиар тус бүр өссөн байна.

Өмнөх 7 хоногтой харьцуулахад хонины ястай махны үнэ 0.1 хувиар буурсан бол үхрийн ястай махны үнэ 5.1 хувь, үхрийн цул махны үнэ 5.2 хувь, ямааны ястай махны үнэ 3.9 хувь, адууны ястай махны үнэ 8.6 хувиар өссөн байна.

2018 оны 6-р сарын 20-ны байдлаар 1 кг хонины /ястай/ мах дунджаар 7490 төгрөг, үхрийн /ястай/ мах 8920 төгрөг, үхрийн цул мах 10790 төгрөг, адууны /ястай/ мах 6600 төгрөг, ямааны /ястай/ мах 5265 төгрөгийн үнэтэй байв (Зураг 1).

Зураг 1. Ястай махны жижиглэн худалдааны дундаж үнэ



Гурилын үнэ: 2018 оны 6-р сарын 20-ны гурилын үнэ өмнөх сараас болон өмнөх 7 хоногоос дээд савласан гурилын үнэ 0.7 хувь, 1-р зэргийн задгай гурилын үнэ 1.4 хувь, 2-р зэргийн савласан гурилын үнэ 0.6 хувиар тус бүр буурсан байна.

Будаа, элсэн чихрийн дундаж үнэ: 2018 оны 6-р сарын 20-ны байдлаар цагаан будааны үнэ өмнөх сар болон өмнөх 7 хоногоос 0.4 хувиар өссөн бол элсэн чихрийн үнэ өмнөх сар болон өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад өөрчлөлтгүй байна.
(Зураг2).

Зураг 2. Цагаан будаа, элсэн чихэр, төмсний дундаж үнэ



Төмс, хүнсний ногооны дундаж үнэ: 2018 оны 6-р сарын 20-ны байдлаар төмс, хүнсний ногооны үнийг өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад төмсний үнэ 19.2 хувь, хүрэн манжингийн үнэ 70.3 хувь, луувангийн үнэ 41.4 хувь, байцааны үнэ 20.7 хувиар өссөн байна. Харин сонгины үнэ 3.2 хувиар буурсан байлаа.

Өмнөх 7 хоногийнхоос төмсний үнэ 3.4 хувь, луувангийн үнэ 20.2 хувь, байцааны үнэ 14.6 хувь, хүрэн манжингийн үнэ 57.3 хувиар өссөн бол сонгины үнэ 3.2 хувиар буурсан байна.

Сүү, өндөг, ургамлын болон цөцгийн тосны дундаж үнэ: 2018 оны 6-р сарын 20-ны байдлаар сүүний үнийг өмнөх сарынхтай харьцуулахад савласан /1 литрийн/ сүүний үнэ 1.6 хувь, задгай сүүний үнэ 2.0 хувь, “элекстер” /0.5 литрийн/ сүүний үнэ 0.4 хувиар буурсан байлаа. Өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад савласан /1 литрийн/ сүүний үнэ 0.9 хувиар буурсан байлаа.

Ургамлын тосны үнэ өмнөх сараас болон өмнөх 7 хоногоос 1.1 хувиар буурсан байна. Цөцгийн тосны үнэ өмнөх сараас 0.1 хувиар өсөж, өмнөх 7 хоногийнхоос өөрчлөлтгүй байлаа.